



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/358

Арвайхээр

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Өвөрхангай АЗЗА” ТӨХК-ийн 11 дүгээр багийн Ноёны гудамж Ноён 3 тоотод байрлах үйлдвэрийн албан конторын зориулалттай 25904м² газрын эзэмших эрхийг иргэн, хуулийн этгээдийн гаргасан хүсэлтийг харгалзан 15 жилийн хугацаагаар сунгаж үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшигч иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгох, газрын улсын бүртгэлд өөрчлөлт хийхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100765



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/358

Арвайхээр

**Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт
шилжүүлсэн хугацаанд зарим арга хэмжээг
авч хэрэгжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.б, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.8 дахь заалт, Улсын Онцгой комиссын 2021 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 23 дугаар хурлын тэмдэглэл, аймгийн Онцгой комиссын 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 34 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн нийт нутаг дэвсгэрт Улаанбаатар хот болон бусад орон нутгаас аялал, зугаалгаар ирж байгаа болон дамжин өнгөрч байгаа иргэдийг бүртгэл мэдээлэлийн системд бүртгэлжүүлж нэвтрүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж, халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлж, хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.

2.Аймгийн нутаг дэвсгэрт ирж байгаа иргэдээс коронавируст халдвар (ковид-19)-ын вакцины бүрэн тунд хамрагдсан өрхийн нэг том хүн, бүрэн тунд хамрагдаагүй 5-аас дээш насны нэг хүүхдээс 24 цагийн дотор авсан PCR эсвэл түргэвчилсэн шинжилгээний хариуг үндэслэн нэвтрүүлэхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Мөнх-Эрдэнэ)-т тус тус үүрэг болгосугай.

3.Амралт, аялал жуулчлал, рашаан сувиллын газруудын үйл ажиллагааг нээж, хариуцлагын гэрээ байгуулж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Иргэд, олон нийтийг эмнэлгийн яаралтай тусламж, эмийн сан, хүнс, шатахуун, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ авахаас бусад тохиолдолд суурин газар, хот айлаар оруулахгүй байхад анхаарч ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Мөнх-Эрдэнэ), сумын Засаг дарга нарт даалгасугай.

5.Амралт, аялал жуулчлал, рашаан сувиллын газруудад нэгдсэн заалаар хооллох, гэр бүл аялалын багууд хооронд аливаа хэлбэрээр нэгдэх, олон нийтийн арга хэмжээ хийх зэргийг хориглосугай.

011100761

2.

6.Замын хяналтын постууд болон төв суурин газруудад коронавируст халдвар (ковид-19)-ын түргэвчилсэн оношилгооны цэгүүдийг хувийн хэвшилд тулгуурлан оновчтой арга хэлбэрээр зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв)-т даалгасугай.

7.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгаж, зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай” А/329 дүгээр захирамжийн 2, 3 дахь заалтыг хүчингүйд тооцсугай.

8.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ